

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/05-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Сүхбаатар сум  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn  
Аудитор: Ц.Отгонбаяр  
Утас: 70362442 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	2-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-20
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. Аудитын илрүүлэлт	22-25
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	26

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан

---



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ЗҮҮНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Э.САРАНБААТАР ТАНАА

2024.03.25 № СЭА-2024/05-НА-СТА-ТТЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 11,564.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 44 дүгээр зүйлийн 44.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7-д заасантай болон Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын 4.2, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай тус тус нийцээгүй байна.

**Асуудлын онцолсон хэсэг**

Сумын ИТХ-ын “Зүүнбүрэн сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 24 дүгээр тогтоолоор тайлант онд 738,789.9 мянган төгрөгийн татварын орлого, 10,320.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 749,109.9 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 668,971.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 10.7 хувиар тасалсан байна.

### **Аудитын гол асуудал**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Захирамж хүчингүй болгох тухай” А/98 дугаар захирамжаар Зүүнбүрэн сумын Засаг даргаар Э.Саранбаатарыг томилсон 2020 оны Б/81 дүгээр захирамжийг хүчингүй болгосон байна.

Зүүнбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Э.Саранбаатарыг дахин нэр дэвшүүлж ирснийг аймгийн Засаг дарга хүлээн авч 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн Б/12 дугаар захирамжаар сумын Засаг даргаар томилсон байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Захирамж хүчингүй болгох тухай” Б/29 дүгээр захирамжаар Зүүнбүрэн сумын Засаг дарга Э.Саранбаатарыг томилсон 2023 оны Б/12 дугаар захирамжийг хүчингүй болгосон байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Б/31 дүгээр захирамжаар Зүүнбүрэн сумын Засаг даргын албан үүргийг сумын Засаг даргын орлогч Б.Батчулуунд хариуцуулснаар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүрэг гүйцэтгэж, төсөв, хөрөнгийг захиран зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сум нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 86.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнаж, хангалттай үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/ мянган төгрөг /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	588,586.3	460,011.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	356,040.5	293,779.0
33	АВЛАГА	188,130.7	119,350.4
35	БАРАА МАТЕРИАЛ	44,415.2	46,882.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,881,691.9	1,994,520.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,881,691.9	1,994,520.1
39200	Биет хөрөнгө	1,865,974.1	1,978,802.3
39300	Биет бус хөрөнгө	15,717.8	15,717.8
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,470,278.2</b>	<b>2,454,531.6</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	53,460.3	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	53,460.3	0.0
41300	Өглөг	53,460.3	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,416,817.9	2454531.6
51	Засгийн газрын хувь оролцоо	2,416,817.9	2,454,531.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	297,811.3	297,811.3
51200	Хуримтлагдсан үр дүн	1,652,781.5	1,690,495.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	466,225.1	466,225.1
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,470,278.2</b>	<b>2,454,531.6</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

/ мянган төгрөг /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,753,790.8</b>	<b>1,693,445.6</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>428,491.6</b>	<b>656,701.0</b>
110	Орлогын албан татвар	189,029.4	331,429.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	189,029.4	346,478.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-15,049.0
113	Хөрөнгийн албан татвар	87,971.9	84,925.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	151,490.3	240,345.5
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>227,017.3</b>	<b>242,108.7</b>
120	Нийтлэг татварын бус орлого	227,017.3	242,108.7
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,098,281.9</b>	<b>794,635.9</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,156,409.1</b>	<b>1,308,641.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,126,409.2</b>	<b>1,308,641.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,109,051.2</b>	<b>1,306,141.2</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,280.7	481,869.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,235.2	61,060.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,666.7	54,673.4
2104	Хангамж, бараа материалын зардал	44,135.8	51,206.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,864.3	28,863.1

2107	Томилолт, зочны зардал	5,079.4	8,715.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,088.2	335,881.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	320,469.8	283,870.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,358.0</b>	<b>2,500.0</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>597,381.7</b>	<b>384,804.4</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,721,096.4</b>	<b>349,388.8</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-4,123,714.7</b>	<b>35,415.6</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>6,533,826.3</b>	<b>0.0</b>	<b>6,533,826.3</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,706.3	0.0	6,706.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,540,532.6	0.0	6,540,532.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-4,123,714.7	0.0	-4,123,714.7
<b>10</b>	<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>2,416,817.9</b>	<b>0.0</b>	<b>2,416,817.9</b>
<b>11</b>	<b>2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	<b>2,416,817.9</b>	<b>0.0</b>	<b>2,416,817.9</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,298.1	0.0	2,298.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,419,116.1	0.0	2,419,116.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	35,415.6	0.0	35,415.6
<b>20</b>	<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>2,454,531.6</b>	<b>0.0</b>	<b>2,454,531.6</b>

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөг /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,690,042.8</b>	<b>1,529,640.5</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>428,491.6</b>	<b>656,701.0</b>
110	Орлогын албан татвар	189,029.4	331,429.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	189,029.4	346,478.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-15,049.0
113	Хөрөнгийн албан татвар	87,971.9	84,925.8

118	Бусад татвар, төлбөр, хураамж	151,490.3	240,345.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	61,837.8	215,621.1
1181	Газрын төлбөр	58,197.0	22,529.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	31,455.4	2,194.5
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>73,468.4</b>	<b>78,303.6</b>
120	Нийтлэг татварын бус орлого	73,468.4	78,303.6
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,188,082.9</b>	<b>794,635.9</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,989,819.4</b>	<b>1,145,373.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,989,819.4</b>	<b>1,145,373.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>881,811.8</b>	<b>1,142,250.9</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	330,552.4	487,844.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,808.2	67,080.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,666.7	54,673.4
2104	Хангамж, бараа материалын зардал	45,852.5	51,289.8
2105	Нормативт зардал	1,290.0	1,118.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,137.9	23,769.0
2107	Томилолт, зочны зардал	4,926.9	8,715.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,485.2	336,038.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,092.0	111,721.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,108,007.6</b>	<b>3,122.9</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>700,223.5</b>	<b>384,266.6</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>461,334.2</b>	<b>419,528.1</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	461,334.2	419,528.1
2200	Дотоод эх үүсвэрээр	461,334.2	419,528.1
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-461,334.2</b>	<b>-419,528.1</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-80,000.0</b>	<b>-27,000.0</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	80,000.0	27,000.0
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>158,889.2</b>	<b>-62,261.5</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	197,151.2	356,040.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	356,040.5	293,779.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөг /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,148,221.80</b>	<b>1,527,374.30</b>	<b>38,769.10</b>	<b>71.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,561,790.30</b>	<b>1,200,485.50</b>	<b>38,993.80</b>	<b>76.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,558,167.40</b>	<b>1,197,362.60</b>	<b>38,993.80</b>	<b>76.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>539,653.90</b>	<b>487,844.10</b>	<b>51,809.80</b>	<b>90.40</b>
210101	Үндсэн цалин	285,657.10	263,003.70	22,653.40	92.07
210102	Нэмэгдэл	146,527.30	127,751.60	18,775.70	87.19
210104	Урамшуулал	9,866.00	2,473.70	7,392.30	25.07
210105	Гэрээт ажлын хөлс	97,603.50	94,615.10	2,988.40	96.94
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>68,811.70</b>	<b>67,080.50</b>	<b>1,731.20</b>	<b>97.48</b>
210201	Тэтгэврийн даатгал	46,829.50	45,944.10	885.40	98.11
210202	Тэтгэмжийн даатгал	5,507.20	5,318.80	188.40	96.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,403.10	4,258.20	144.90	96.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,097.00	987.40	109.60	90.01
210205	Эрүүл мэндийн даатгал	10,974.90	10,572.00	402.90	96.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>412,060.30</b>	<b>338,279.70</b>	<b>73,780.60</b>	<b>82.09</b>
210301	Гэрэл, цахилгаан	89,182.00	64,854.20	24,327.80	72.72
210302	Түлш, халаалт	305,491.30	257,006.50	48,484.80	84.13
210303	Цэвэр, бохир ус	17,387.00	16,419.00	968.00	94.43
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>54,473.80</b>	<b>49,181.90</b>	<b>5,291.90</b>	<b>90.29</b>
210401	Бичиг хэрэг	7,719.90	7,036.50	683.40	91.15
210402	Тээвэр, шатахуун	26,094.40	26,106.40	-12.00	100.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,881.60	4,347.90	533.70	89.07
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,391.40	6,817.50	3,573.90	65.61
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,386.50	4,873.60	512.90	90.48
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,909.90</b>	<b>1,118.70</b>	<b>3,791.20</b>	<b>22.78</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,909.90	1,118.70	3,791.20	22.78
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>111,642.30</b>	<b>102,582.90</b>	<b>9,059.40</b>	<b>91.89</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,259.50	16,286.40	-26.90	100.17
210602	Тавилга	15,000.00	15,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	583.70	0.00	583.70	0.00
210604	Урсгал засвар	79,799.10	71,296.50	8,502.60	89.34
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,027.70</b>	<b>8,715.90</b>	<b>311.80</b>	<b>96.55</b>
210702	Дотоод албан томилолт	9,027.70	8,715.90	311.80	96.55
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,859.20</b>	<b>15,578.90</b>	<b>6,280.30</b>	<b>71.27</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,996.50	14,729.90	5,266.60	73.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	262.90	0.00	262.90	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	154.30	74.30	80.00	48.15
210804	Тээврийн хэрэгслийн татвар	413.20	413.10	0.10	99.98
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	279.00	253.00	26.00	90.68

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	628.00	0.00	628.00	0.00
210807	Газрын төлбөр	97.10	97.10	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6.60	0.00	6.60	<b>0.00</b>
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21.60	11.50	10.10	53.24
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>335,728.60</b>	<b>126,980.20</b>	<b>208,748.40</b>	<b>37.82</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	334,109.70	126,600.20	207,509.50	37.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,618.90	380.00	1,238.90	23.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,622.90</b>	<b>3,122.90</b>	<b>500.90</b>	<b>86.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,622.90</b>	<b>3,122.90</b>	<b>500.90</b>	<b>86.20</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,622.90	3,122.00	500.90	86.17
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>491,668.20</b>	<b>299,888.80</b>	<b>191,779.40</b>	<b>60.99</b>
222001	Тоног төхөөрөмж	255,267.00	199,107.20	56,159.80	78.00
223001	Бусад хөрөнгө	236,401.20	100,781.60	135,619.60	42.63
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>94,763.30</b>	<b>27,000.00</b>	<b>67,763.30</b>	<b>28.49</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	94,763.30	27,000.00	67,763.30	28.49
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,148,221.80</b>	<b>1,571,180.70</b>	<b>577,041.10</b>	<b>73.14</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,755,661.20</b>	<b>1,505,147.70</b>	<b>250,513.50</b>	<b>85.73</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,542,386.40	1,262,517.60	279,868.80	81.85
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	213,274.80	242,630.10	67,361.10	113.76
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>392,560.60</b>	<b>66,033.00</b>	<b>326,527.60</b>	<b>16.82</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	97,877.10	66,033.00	31,844.10	67.47
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	291,035.50	0.00	291,035.50	0.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	2	2	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>29</b>	<b>25</b>	<b>4</b>	<b>86.21</b>
620001	Удирдах ажилтан	7	6	1	85.71
620002	Гүйцэтгэх ажилтан	10	7	3	70.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.00
620004	Гэрээт ажилтан	7	7	-	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>29</b>	<b>25</b>	<b>4</b>	<b>86.21</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	8	3	72.73
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	5	1	83.33

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөг /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>86,651.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>37,151.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>15,027.60</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,107.90</b>
210401	Бичиг хэрэг	898.30
210402	Тээвэр, шатахуун	670.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	539.10
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,001.00</b>
210604	Урсгал засвар	1,001.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>350.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,568.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,568.70
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22,124.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	22,124.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>49,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>49,500.00</b>
220001	Барилга байгууламж	20,000.00
222001	Тоног төхөөрөмж	29,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>86,651.60</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,108.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,611.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	63,931.10

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “*Өрхийг дэмжсэн өсөлтийн бодлогыг хэрэгжүүлж, төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ*” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан

шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлт тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбүрэн ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зүүнбүрэн сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус сумын төсөвт байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,746.6 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	356,040.50	293,779.00	(62,261.50)
Авлага	188,130.70	119,350.40	(68,780.30)
Бараа материал	44,415.20	46,882.00	2,466.80
Үндсэн хөрөнгө	1,881,691.90	1,994,520.10	112,828.20
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,470,278.30</b>	<b>2,454,531.50</b>	<b>(15,746.80)</b>
Өр төлбөр	53,460.30	-	(53,460.30)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,416,817.90	2,454,531.60	37,713.70

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,470,278.20	2,454,531.60	(15,746.60)
---------------------------------------	--------------	--------------	-------------

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр засгийн газрын хувь оролцоо данснуудыг дор тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 293,779.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 62,261.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	356,040.50	293,779.00	(62,261.50)
Төрийн сангийн харилцах	356,040.50	293,779.00	(62,261.50)
<b>Дүн</b>	<b>356,040.50</b>	<b>293,779.00</b>	<b>(62,261.50)</b>

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 71,352.3 мянган төгрөг, ОНХС-ийн 143,377.3 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн 79,049.3 мянган төгрөг тус тус байршиж байна

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 119,350.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 68,780.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	1,639.90	2,308.10	668.20
Байгууллагаас авах авлага	48,682.30	7,385.80	(41,296.50)
Хувь хүмүүст олгосон зээл	137,808.50	109,656.50	(28,152.00)
<b>Дүн</b>	<b>188,130.70</b>	<b>119,350.40</b>	<b>(68,780.30)</b>

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд ХХС-ийн үндсэн зээлийн 109,656.5 мянган төгрөг, зээлийн хүүгийн 2,308.1 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна. Мөн сумын ЗДТГ нь Засгийн газрын 2023 оны 52 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн албан хаагчдад 1 сарын үндсэн цалингийн урамшуулал олгохоор тооцож, гүйлгээ хийсэн боловч цалингийн гүйлгээ нь баталгаажаагүйгээс НДШ, ХХОАТ-ын авлага үүссэн байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 46,882.0 мянган төгрөг болж, өмнөх СЭА-2024/05-НА-СТА-ТТЗ

оноос 2,466.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	3,105,105.46	4,149,755.46	1,044,650.00
Аж ахуйн материал	9,839,200.00	11,365,200.00	1,526,000.00
Сэлбэг хэрэгсэл	620,000.00	0.00	(620,000.00)
Түлш, шатах тослох материал	0	960,000.00	960,000.00
Барилгын засварын материал	512,000.00	0.00	(512,000.00)
Бусад хангамжийн материал	30,338,871.40	30,407,083.40	68,212.00
<b>Дүн</b>	<b>44,415,176.86</b>	<b>46,882,038.86</b>	<b>2,466,862.00</b>

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд 126,368.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, аймгийн ГБХЗХГ-аас 637.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан болон 124,538.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,994,520.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 112,828.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>1,865,974.10</b>	<b>1,978,802.30</b>	<b>112,828.20</b>
Барилга, байгууламж, орон сууц	977,601.80	955,550.10	(22,051.70)
Авто-тээврийн хэрэгсэл	38,803.50	190,064.80	151,261.30
Машин тоног төхөөрөмж(компьютер)	36,500.30	40,853.60	4,353.30
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,256.60	21,997.90	14,741.30
Зам гүүрийн байгууламж	284,812.40	253,899.80	(30,912.60)
Бусад үндсэн хөрөнгө	520,999.50	516,436.10	(4,563.40)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>15,717.80</b>	<b>15,717.80</b>	-
Бусад биет бус хөрөнгө	15,717.80	15,717.80	-
<b>Дүн</b>	<b>1,881,691.90</b>	<b>1,994,520.10</b>	<b>112,828.20</b>

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 69,800.0 мянган төгрөгийн хогны автомашин, 94,950.0 мянган төгрөгийн ковш худалдан авсан,

- Сумын ЗДТГ нь төсвийн хөрөнгөөр 16,286.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 15,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Оны эхний үлдэгдэл 53,460.3 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулснаар өр төлбөр данс жилийн эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	4,778.10	-	(4,778.10)
Байгууллагад төлөх өглөг	48,682.20	-	(48,682.20)
<b>Дүн</b>	<b>53,460.30</b>	<b>-</b>	<b>(53,460.30)</b>

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эхний үлдэгдэлд ЗДТГ-ын 4,778.1 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын 29,500.0 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн 19,182.2 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсаныг тайлант онд барагдуулж ажилласан байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,454,531.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 37,713.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	297,811.30	297,811.30	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,652,781.50</b>	<b>1,690,495.20</b>	<b>37,713.70</b>
Өмнөх үеийн үр дүн	5,776,496.20	1,655,079.60	(4,121,416.60)
Тайлант үеийн үр дүн	(4,123,714.70)	35,415.60	4,159,130.30
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	466,225.10	466,225.10	-
<b>Дүн</b>	<b>2,416,817.90</b>	<b>2,454,531.60</b>	<b>37,713.70</b>

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

## Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын “Зүүнбүрэн сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 24 дүгээр тогтоолоор тайлант онд 738,789.9 мянган төгрөгийн татварын орлого, 10,320.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **749,109.9** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **668,971.6** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 10.7 хувиар тасалдуулсан байна.

Хүснэгт 8. Төсвийн орлогын гүйцэтгэл

№	Татварын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	<b>Татварын орлого</b>	<b>738,790.00</b>	<b>656,701.00</b>	<b>(82,089.00)</b>	<b>88.89</b>
2	<b>Хүн амын орлогын албан татвар</b>	<b>264,150.30</b>	<b>331,429.70</b>	<b>67,279.40</b>	<b>125.47</b>
3	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	222,952.6	266,091.80	43,139.20	119.35
	Хүн амын буцаан олголт	(15,049.0)	(15,049.04)	-	100.00
4	Үйл ажиллагааны орлого	30,064.1	36,473.10	6,409.00	121.32
5	Хөрөнгө борлуулсны орлого	900.0	11,190.00	10,290.00	1,243.33
6	Хөрөнгийн орлого/ Хадгаламжийн хүүгийн татварын орлого/	25,282.6	32,723.80	7,441.20	129.43
7	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>126,416.80</b>	<b>84,925.80</b>	<b>(41,491.00)</b>	<b>67.18</b>
8	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	10,413.7	16,364.70	5,951.00	157.15
9	Бууны албан татвар	240.0	1,200.00	960.00	500.00
10	Малд ноогдуулах албан татвар	115,763.1	67,361.10	(48,402.00)	58.19
11	<b>Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар</b>	<b>312,996.90</b>	<b>215,621.10</b>	<b>(97,375.80)</b>	<b>68.89</b>
12	Улсын тэмдэгтийн хураамж	56.9	307.10	250.20	539.72
13	Хог хаягдлын хураамжийн орлого	2,060.00	3,504.00	1,444.00	170.10
14	ТТАМАТ	310,880.0	211,810.00	(99,070.00)	68.13
15	<b>Газрын төлбөр</b>	<b>32,166.00</b>	<b>22,529.90</b>	<b>(9,636.10)</b>	<b>70.04</b>
16	Газрын төлбөр	23,090.5	20,559.00	(2,531.50)	89.04
17	Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	9,075.5	1,970.90	(7,104.60)	21.72
18	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>3,060.00</b>	<b>2,194.50</b>	<b>(865.50)</b>	<b>71.72</b>
	Ус рашаан ашигласны төлбөр	3,000.00	-	(3,000.00)	-
19	Ойн нөөц ашигласны төлбөр		66.50	66.50	
20	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	60.00	60.00	-	100.00
21	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		2,068.00	2,068.00	
22	<b>Татварын бус бусад орлого</b>	<b>10,320.00</b>	<b>12,270.60</b>	<b>1,950.60</b>	<b>118.90</b>
23	нэр заагаагүй бусад орлого	320.0	320.60	0.60	100.19
24	Хүү, торгуулийн орлого	10,000.0	11,950.00	1,950.00	119.50
	<b>Нийт дүн</b>	<b>749,110.00</b>	<b>668,971.60</b>	<b>(80,138.40)</b>	<b>89.30</b>

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 43,139.2 мянган төгрөгөөр давж биелсэн хэдий ч түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 99,070.0 мянган төгрөгөөр, малд ноогдуулах албан татвар 48,402.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

СЭА-2024/05-НА-СТА-ТТЗ

### Давж биелсэн орлого:

- **Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого:** Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдэж, 43,139.2 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

### Тасарсан орлого:

- **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого:** “Дархан-Сэлэнгийн авто замаас Түшиг-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам”-ын гүйцэтгэгч Монгол ЛЗ ХХК нь Засгийн газраас санхүүжилт дутуу авснаас шалтгаалан хайрга дайрга ашигласны төлбөрт 211,810.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 99,070.0 мянган төгрөгөөр тасарсан,
- **Малд ногдуулах албан татвар:** Удаан хугацаанд татварын байцаагчгүй ажиллаж, малчин болон мал бүхий иргэдийн татварыг бүрэн төлүүлээгүйгээс уг орлого 48,402.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 969,513.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 43 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 523,328.8 мянган төгрөг, ерөнхий орлогын оны эхний үлдэгдлээс 127,782.4 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 133,274.9 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 200,572.9 мянган төгрөг, ХХС-ийн эхний үлдэгдлээс 45,345.3 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 53,154.7 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 672,811.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 3,648.0 мянган төгрөг зэрэг нийт 1,759,918.7 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 24 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 749,110.0 мянган төгрөгөөр, урьд оны ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 127,782.4 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 133,275.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 242,630.1 мянган төгрөгөөр, ХХС-ийн эхний үлдэгдлээс 45,345.3 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 53,154.7 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 793,276.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 3,648.0 мянган төгрөг зэрэг нийт **2,148,221.8** мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулахаар баталсан байна.

### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 514,991.9 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 242,630.1 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 63,600.9 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 668,971.6 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, урьд оны ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 78,554.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 2,432.0 мянган төгрөг нийт 1,571,180.7 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлж, 1,527,374.3 мянган төгрөгийг зарцуулан зардлын гүйцэтгэл 71.1 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин, НДШ-ийн зардал 53,541.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 73,780.6 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардал 5,291.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 9,059.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 6,280.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 208,748.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 191,779.4 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээл 67,763.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 12 төсөл, арга хэмжээнд 282,174.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 81,516.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 4 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 17 төсөл, арга хэмжээнд 491,758.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 299,888.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 8 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс 1,108.6 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 39,500.0 мянган төгрөг, ОНХО-аас 20,000.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 711.9 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхдийн чуулга, уулзалтын зардалд 600.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 24,731.1 мянган төгрөг зэрэг нийт 86,651.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд Зүүнбүрэн сумын ОНХО-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 152,782.4 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 329,630.1 мянган төгрөгийн 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зэрэг нийт 8 төсөл, арга хэмжээний цахим тендерийн урилгыг tender.gov.mn цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зүүнбүрэн ТТЗ-ийн сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн зардлыг холбогдох арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар бодитой төлөвлөж, хэрэгжүүлэх, төлөөлөгчдийн цай, хоолны зардлыг гүйцэтгэлээр тооцож олгох, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,156,409.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **11,564.0** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус сум нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Автомашинуудад цэнхэр дугаар авсан,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд, бусад арга хэмжээнүүдтэй холбогдуулан контент, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй зэрэг төсвийн захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Хүснэгт 10. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал*

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	170	161	9	-
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	161	159	2	-
3	Сумын Засаг даргын Тамгын газар	161	158	3	-
	<b>Нийт дүн</b>	<b>492</b>	<b>478</b>	<b>14</b>	

Тайлант хугацаанд ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 18-20 төрлийн нийт 492 мэдээллээс 478 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 11 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,088.0	1	1,088.0	100.0
Албан шаардлага	3	9,491.6	3	9,491.6	100.0
Зөвлөмж	1	1,714.8	1	1,714.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>12,294.4</b>	<b>5</b>	<b>12,294.4</b>	<b>100.0</b>

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 102,195.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 90,050.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 12,144.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 80,138.4 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Төсвийн орлогын төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авч, орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс чөлөөт уран бүтээлч Ц.Цолмонбаатарын дууны клипний зардалд 2,500.0 мянган төгрөг, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын дуучин С.Бүрэнжаргалын уран бүтээлийн тоглолтод 2,000.0 мянга төгрөгийг тус тус санхүүжүүлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.” 15.1.4 дахь “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр сумын ЗДТГ нь төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлого 2,352.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-д “Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.”, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 4.2-д “Орон нутгийн төсөвт байгууллагын ... энэ журмын 3.1.1-т заасан орлогыг зарцуулах хүсэлтийг аймаг, ... сум .. Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс энэхүү журмын 4.1-д заасан хугацааны дотор хянаж тухайн шатны Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ. ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, зарцуулах эрх авсны үндсэн дээр зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Сумын ИТХ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 250 иргэнд сургалт зохион байгуулахад анхан шатны баримт / цайны зардал, тараах материал, тэмдэглэлийн дэвтэр, бал зэрэг материал /-ын бүрдэлгүйгээр 1,560.0 мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын

*бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.*

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.** Сумын ЗДТГ нь бараа ажил, үйлчилгээний бусад зардлаас 1 удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 1500.0 мянган төгрөгийг гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

**1.1.1 Илрүүлэлт:** Сумын ЗДТГ-ын төрийн өмчийн барилгын тогтмол зардлын /80111/ арга хэмжээний урсгал засварын зардлын батлагдсан төсвөөс байгууллагын үндсэн үйл ажиллагаатай /80101/ холбоотой гарах тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар үйлчилгээний зардалд 1,590.0 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “*Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал*”-ын “*80101: Үндсэн үйл ажиллагааны зардал*”, “*80111:Төрийн өмчийн барилгын тогтмол зардал*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-тай тус тус нийцэхгүй байна.

**1.1.2 Өгсөн зөвлөмж:** Төсвийн зардлыг холбогдох арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар бодитой төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах.

**1.2.1 Илрүүлэлт:** Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх арга хэмжээнд зарцуулагдах 6,817.5 мянган төгрөгийн зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын хавсралтад заасан зардлын ангилал, нэр төрлөөр бус хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлыг бүлэг, зүйлээр төлөвлөж, хянах зарчмыг алдагдуулж байна.

**1.2.2 Өгсөн зөвлөмж:** Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх арга хэмжээний зардлын төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж байх.

## **2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой.**

**Илрүүлэлт:** ИТХурлын төлөөлөгчдийн хуралдааны цай, хоолны 3,737.2 мянган төгрөгийн зардлыг гүйцэтгэлээр бус төлөвлөсөн дүнгээр Марат, Болор-Эмүүн, Бодлын хишиг зэрэг компаниудад шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Төлөөлөгчдийн цай, хоолны зардлыг гүйцэтгэлээр тооцож, шилжүүлж байх.

## **3. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Сумын ИТХ нь жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт болон нормыг бүрэн бүртгээгүй нь хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт “*Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар*”-ын 3.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтөлж, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>1</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зүүнбүрэн сумын ТТЗ	9	102,195.1			5	90,050.4	4	12,144.7				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>102,195.1</b>			<b>5</b>	<b>90,050.4</b>	<b>4</b>	<b>12,144.7</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 14 мэдээллийг хугацаа хоцроосон	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>